



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/28

Цагаан-Овоо

Тамхи худалдах тусгай зөвшөөрлийг
сунгах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 зүйлийн 1, 8.2 дугаар зүйлийн 11.6, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14, 7 дугаар зүйлийн 7.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "Буянт наран говь" ХХК-д олгосон тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр хүртэл хугацаагаар сунгасугай.

2. Утаат тамхи худалдан борлуулах үйл ажиллагаа эрхлэхдээ хууль, журамд заасан шаардлагыг биелүүлж, үйл ажиллагаа эрхлэн явуулж буй байр, байгууллагын эргэн тойрны цэвэрлэгээ болон тохижилтод анхаарч, холбогдох хууль тогтоомжийг баримтлан хэрэгжүүлж ажиллахыг "Буянт наран говь" ХХК (Б.Сувдаа)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын Газрын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (С.Отгонсүрэн), цагдаагийн хэсгийн төлөөлөгч (Д.Мөнхбаатар) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ӨЛЗИЙХИШИГ